



УЛСЫН ХИЛЭЭР ОРУУЛЖ, ГАРГАЖ БУЙ БЭЛЭН ВАЛЮТЫН СУДАЛГАА

Боловсруулсан: ВЭЗГ, ТТССХ-ийн эдийн засагч Т.Түвшингэрэл

ХУРААНГУЙ

Сүүлийн 1 жилд¹⁶⁷ Замын-Үүд, Буянт Ухаа боомтуудаар Монгол Улсын хилээр нэвтэрсэн нийт иргэдийн **66%**, ГЕГ-ын бүртгэдэг өндөр дүнтэй бэлэн валютын урсгалын **82%** дамжин өнгөрсөн байна. Иймд хамгийн их ачаалалтай, үүргийн худалдаа идэвхитэй хийгддэг эдгээр боомтуудад түүвэр судалгааг зохион байгуулж, нийт 2,344 зорчигчдыг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хамруулсан. Түүнчлэн арилжааны банкуудын нэгдсэн балансын кассын үлдэгдэл болон банкуудын бэлэн валютын зузаатгалд үндэслэн банкны системээс гадагшилж буй бэлэн валютыг тодорхойлж, түүвэр судалгааны үр дүнтэй харьцуулав.

Түүвэр судалгааг 2013 онд гүйцэтгэсэн ба судалгааны үр дүнд голлох боомтуудаар сард дунджаар цэвэр дүнгээр **80 сая ам.доллар**тай тэнцэх хэмжээний бэлэн валют гадагшилж байна. Тухайлбал, Замын-Үүд боомт нь сард **1.9 сая ам.долларын** орох, **59.7 сая ам.долларын** гарах урсгалтай, Буянт Ухаа боомт нь **6.2 сая ам.долларын** орох, **28.0 сая ам.доллар**тай тэнцэх хэмжээний бэлэн валютын гарах урсгалтай байна. Харин банкуудын нэгдсэн баланс, зузаатгалын мэдээнд үндэслэсэн тооцооллын үр дүнд 2013 оны эхний 6 сард банкны системээс **478 сая ам.доллар** гадагшилж, иргэд, аж ахуйн нэгжүүд удаан хугацаанд гадаад валютыг бэлнээр хадгалдаггүй гэж таамаглавал энэ дүнгээр хилээр гарсан гэж үзэж болно. Тиймээс банкны бэлэн валютын дансанд үндэслэсэн тооцоо болон түүвэр судалгааны үр дүн нь хоорондоо нийцтэй байна.

Валютын бүтцийн хувьд Замын-Үүд боомтоор нэвтэрч буй бэлэн валютын эргэлтийн **85%**-ийг юань, **7%**-ийг ам.доллар эзэлж байгаа бол Буянт Ухаа боомтоор дамжих бэлэн валютын эргэлтийн **55%**-ийг ам.доллар, **25%**-ийг юань тус тус эзэлж байна.

Түлхүүр үгс: Валютын зах, Бэлэн валютын урсгал


¹⁶⁷ 2012 оны сүүлийн хагасаас 2013 оны эхний хагас жил хүртэлх хугацааг хэлнэ.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хилээр 2012 оны байдлаар давхардсан тоогоор 4.5 сая хүн зорчсон байна. Эдгээр хүмүүсийн биедээ авч нэвтэрдэг бэлэн валютын урсгалыг үнэн зөв тодорхойлох нь Төлбөрийн тэнцлийн статистикийн чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Манай улсад байнгын болон байнгын бус 24 хилийн боомт үйл ажиллагаа явуулж байгаагийн 10 нь ОХУ-тай¹⁶⁸, 12 нь БНХАУ-тай¹⁶⁹ хил залгаа оршдог ба агаарын 2 боомт бий. Эдгээр боомтуудаар нэвтэрч буй өндөр дүнтэй бэлэн валютын мэдээг¹⁷⁰ Гаалийн ерөнхий газраас сар бүр ирүүлдэг бөгөөд энэ нь одоогоор Төлбөрийн тэнцлийн бэлэн мөнгө, харилцах дансны мэдээллийн эх сурвалжаар ашиглагдаж байна.

Зураг 1. Гаалийн мэдээ дэх валютын урсгал (цэвэр)




Эх сурвалж: ГЕГ

¹⁶⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-г хавсаргасан.

¹⁶⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-г хавсаргасан.

¹⁷⁰ Улсын хилээр оруулж, гаргаж буй 5 сая төгрөгөөс дээш дүнтэй бэлэн валютын мэдээ

Зураг 2. Боомт тус бүрийн хувийн жин



Эх сурвалж: ГЕГ, ХХЕГ

Гаалийн бэлэн валютын мэдээнээс үзэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд цэвэр дүнгээр 165.5 сая ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валют хилээр гадагшилсны 66%-ийг ам.доллар, 27%-ийг юань тус тус эзэлсэн байна. Сард 900 сая орчим ам.долларын гадаад худалдааны эргэлттэй манай орны хилээр 7.5 сая ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валют эргэлддэг статистик үзүүлэлттэй байгаа нь бага дүн тул түүвэр судалгаагаар бэлэн валютын урсгалыг тодорхойлж, зорчигчдын улсын хилээр оруулж, гаргаж буй бэлэн валютын нийт дүнг төлбөрийн тэнцэлд тусгах шаардлага гарсан.

Энэ чиглэлээр ВЭЗГ нь 2005, 2012 онуудад түүвэр судалгаа хийж байсан бөгөөд энэ удаагийн судалгаагаар 2012 оны судалгааны үр дүнг бататгах, цаашид төлбөрийн тэнцэлд ашиглах нэгж зорчигчид оногдох бэлэн валютын урсгалын дундаж дүнг тодорхойлохыг зорилоо.

Сүүлийн 1 жилд¹⁷¹ Монгол Улсын хилээр нэвтэрсэн нийт иргэдийн 66%, ГЕГ-ын өндөр дүнтэй бэлэн валютын урсгалын мэдээний 82%-ийг Замын-Үүд, Буянт Ухаа боомтууд тус тус эзэлж байгаа тул түүвэр судалгаанд хамгийн их ачаалалтай, үүргийн худалдаа идэвхтэй хийгддэг эдгээр боомтуудыг хамруулсан.

¹⁷¹ 2012 оны сүүлийн хагасаас 2013 оны эхний хагас жил хүртэлх хугацааг хэлнэ.

2. БЭЛЭН ВАЛЮТЫН ТҮҮВЭР СУДАЛГАА

2.1. Судалгааны аргазүй, түүвэр

Судалгааны анкетыг монгол, англи, хятад, солонгос, орос хэлүүдээр боловсруулж, Улаанбаатар, Замын-Үүд чиглэлийн галт тэрэг, Замын-Үүд, Буянт Ухаа боомтуудын хилийн хамгаалалтын бүс газруудад түүвэрлэлтийг тус тус гүйцэтгэж, судалгаанд нийт 2,344 зорчигчдыг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хамрууллаа. Түүнчлэн бэлэн валютын урсгалын талаар иргэд, ченж, арилжааны банкуудын саналыг авч тайланд тусгасан. Үүргийн худалдаа идэвхитэй хийгддэг Замын-Үүд боомтын тухайд тэмдэглэлт ойн нөлөөллийг тооцох зорилгоор улсын баяр наадмын өмнө болон дараа түүвэрлэлтийг хийлээ.

Хүснэгт 1. Түүврийн тайлбар

Боомт	Буянт Ухаа		Замын-Үүд	
Хугацаа	10/3-10/4		7/4-6, 7/25-27	
Иргэншил	Монгол	Гадаад	Монгол	Гадаад
Хилээр зорчсон байдал	гарах	орох	гарах	орох
Түүврийн хэмжээ	210	219	1659	256


Судалгааны маягт болон үр дүнг боловсруулахад дараах таамаглалуудад үндэслэсэн. Үүнд:

- хилээр гарч буй Монгол иргэд авч гарсан бэлэн валютаа гадаадад хэрэглэж дуусгадаг,
- хилээр орж буй гадаад иргэд авч орсон бэлэн валютаа дотоодод хэрэглэж дуусгадаг,
- насанд хүрээгүй зорчигч бэлэн валют биедээ авч хил нэвтэрдэггүй.

2.2. Судалгааны нэгдсэн дүн


Түүврийн бэлэн валютын орох, гарах урсгалын хистограм нь зүүнээс баруун тийш буурсан хэлбэртэй байна.

Зураг 3. Бэлэн валютын гарах урсгалын хистограм



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4. Бэлэн валютын орох урсгалын хистограм




Эх сурвалж: Монголбанк

Гарах урсгал. Аяллын зорилгоос хамааран зорчигчид дунджаар Замын-Үүд боомтоор 800-2000 ам.доллар, Буянт Ухаа боомтоор 1300-5300 ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валют биедээ авч хилээр гарч байна. Үүргийн худалдаа идэвхитэй хийгддэг Замын-Үүд боомтын хувьд баяр ёслол, тэмдэглэлт ойн өмнөх өдрүүдэд авч гарах бэлэн валютын хэмжээ энгийн үеэс 15%-иар өндөр байна. Түүнчлэн ижил өдөр хилийн хяналтын бүсээс авсан түүврийн дундаж утга нь галт тэргэнд авсан түүврийн утгаас 2 дахин бага дүнтэй байгаагаас үзэхэд зорчигчид хилээр авч гарч буй бэлэн валютын бодит дүнгээ гаальд дарж мэдүүлдэг магадлалтай болохыг харуулж байна.

Орох урсгал. Буянт Ухаа боомтоор орж ирж буй гадаад иргэдийн дийлэнх нь аялал болон албан томилолтын зорилгоор зорчиж байгаа бөгөөд дунджаар 700-1400 ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валюттай хилээр орж байна. Замын-Үүд боомтын хувьд ажиллах болон хувийн чанартай зорилгоор хилээр орж буй Хятадууд гадаад зорчигчдын дийлэнх хэсгийн эзэлж, дунджаар 300-600 ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валюттай хилээр орж байна.

Зураг 5. Бэлэн валютын урсгалын бүтэц



Боомтын байршлаас шалтгаалан хилээр авч нэвтрэх валютын бүтэц өөр байна. Замын-Үүд боомтын орох, гарах урсгалын аль алинд юань дийлэнх хэсгийг

бүрдүүлж байгаа бол Буянт Ухаа боомтын тухайд ам.доллар голчилж байна. Замын-Үүд боомтоор хилээр гарагсдын 35 орчим хувь нь тодорхой хэмжээний Монгол төгрөгтэй хил нэвтэрдэг ба энэ нь эргэж орж ирэхэд гаалийн татвар төлөх, Эрээн хотод валют худалдаж авахад ашиглагддаг байна.

2.3 НЭМЭЛТ ТООЦООЛОЛ

Сүүлийн 1 жилийн хугацаанд хилээр нэвтэрсэн иргэдийн тоо болон энэ удаагийн түүвэр судалгааны 1 зорчигчид оногдох бэлэн валютын медиан дүнд үндэслэн тооцооллыг гүйцэтгэвэл тайлант хугацаанд Буянт Ухаа, Замын-Үүд боомтуудаар цэвэр дүнгээр нийт 956 сая ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валют гадагшилсан байна. Үүний ойролцоогоор 20%-ийг ам.доллар, 70%-ийг юань эзэлж байна.

Хүснэгт 2. Сүүлийн 1 жилийн хугацаанд 2 боомтоор оруулж, гаргасан бэлэн валютын дүн

	Буянт Ухаа			Замын-Үүд			Нийт		
	Орсон	Гарсан	Зөрүү	Орсон	Гарсан	Зөрүү	Орсон	Гарсан	Зөрүү
Нийт	74.0	336.0	-262.0	23.0	716.9	-693.9	97.0	1052.9	-955.9
Ам.доллар	41.5	184.8	-143.3	1.4	50.2	-48.8	42.8	235.0	-192.1
Юань	13.3	90.7	-77.4	19.3	609.4	-590.0	32.7	700.1	-667.4
Бусад	19.2	60.5	-41.2	2.3	57.4	-55.1	21.5	117.8	-96.3


Эх сурвалж: ХХЕГ

Түүвэр судалгааны дүн нь ГЕГ-ийн өндөр дүнтэй бэлэн валютын мэдээнээс 13 дахин өндөр байна.

3. БАНКУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАН, ЗУЗААТГАЛЫН МЭДЭЭНД ҮНДЭСЛЭСЭН ТООЦООЛОЛ

Банкны систем дэх нийт бэлэн валют нь банкуудын нэгдсэн тайлангийн “Касс дахь бэлэн мөнгө” гэсэн дансанд бүртгэгддэг бөгөөд энэхүү дансны үлдэгдлийн өөрчлөлтөөр банкны систем дэх бэлэн валютын урсгалыг тайлбарлах боломжтой. Банкны системийн нийт бэлэн валютын урсгалыг Зураг 6-д дурдсан хүчин зүйлсээр тайлбарлаж болно.

Зураг 6. Банкны систем дэх нийт бэлэн валютын урсгалыг тайлбарлагч хүчин зүйлс



Банкны системээс гадагшилж буй бэлэн валютын урсгалыг Зураг 6-д үзүүлсэн 3, 4, болон 5 дахь үзүүлэлтүүдээр тайлбарлана. Банкны иргэд, ААНБ-аас худалдаж авсан бэлэн валют, харилцах, хадгаламжинд татсан бэлэн валют, зээл төлсөн бэлэн валют эерэг байх нь банкны системд дотоод захаас бэлэн валют орж ирсэнийг илэрхийлнэ. Харин сөрөг бол банкны системээс бэлэн валют гарсныг илэрхийлнэ.

Уг аргачлалаар тооцсон 2011-2014 оны эхний хагас жилүүдийн бэлэн валютын дотоод цэвэр урсгалын дүнг Хүснэгт 3-т харьцуулан үзүүлэв.


Хүснэгт 3. Банкуудын нэгдсэн тайлан, зузаатгалын мэдээнд үндэслэсэн тооцооллын үр дүн

Ангилал	Эхний хагас жил			2013/2012 Δ		2014/2013 Δ	
	2012	2013	2014	Дүн	%	Дүн	%
Эхний үлдэгдэл	103	105	118	2	2%	13	12%
Гаднаас татсан цэвэр зузаатгал	326	363	246	37	11%	-117	-32%
МБ-наас татсан цэвэр зузаатгал	216	101	73	-115	-53%	-28	-28%
Дотоод цэвэр урсгал	542	478	326	-64	-12%	-152	-32%
Эцсийн үлдэгдэл	103	91	110	-12	-12%	19	21%

Эх сурвалж: Г.Эрдэнэбулган, Б.Гэрэлмаа, Б.Цэнгүүнжав (2014), “Монгол Улсын валютын захын бэлэн валютын судалгаа”

Тодруулбал, банкуудын нэгдсэн тайлан, зузаатгалын мэдээнд үндэслэсэн тооцооллоор 2013 оны эхний хагас жилд банкны системээс 478 сая ам.доллар бэлнээр гадагшилсан ба иргэд, аж ахуйн нэгжүүд арилжааны банкнаас авсан валютаа удаан хугацаагаар бэлнээр барьдаггүй гэж үзвэл дээрх хугацаанд 478 сая ам.доллар хилээр бэлнээр гарсан гэж дүгнэж болно (Зураг 7).

Зураг 7. Банкуудын нэгдсэн тайлан, зузаатгалын мэдээнд үндэслэсэн тооцооллын үр дүн



Эх сурвалж: Г.Эрдэнэбулган, Б.Гэрэлмаа, Б.Цэнгүүнжав (2014), “Монгол Улсын валютын захын бэлэн валютын судалгаа”

Харин хилээр гарч буй бэлэн валютын түүвэр судалгаагаар 2013 онд сард дунджаар 80 сая ам.доллар бэлэн валют хилээр гардаг гэсэн үр дүнд хүрсэн нь хагас жилд ойролцоогоор 480 сая ам.доллар гарсан буюу банкуудын нэгдсэн тайлан, зузаатгалын мэдээнд үндэслэсэн тооцооллын үр дүнтэй ойролцоо байгаа нь түүвэр судалгааны үр дүнг бататгаж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Тус судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

- Хилээр 1 зорчигч дунджаар 800-1,600 ам.доллартай тэнцэх хэмжээний валютыг биедээ бэлнээр авч гарч, 250-800 ам.доллартай тэнцэх хэмжээний валютыг бэлнээр авч орж байна.
- Судалгааны үр дүнд үндэслэн тооцвол голлох боомтуудаар сард дунджаар цэвэр дүнгээр 80 сая ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валют гадагшилж байна. Тухайлбал Замын-Үүд боомт нь сард 1.9 сая ам.долларын орох, 59.7 сая ам.долларын гарах урсгалтай, Буянт Ухаа боомт нь 6.2 сая ам.долларын орох, 28.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний бэлэн валютын гарах урсгалтай байна.
- Валютын бүтцийн хувьд Замын-Үүд боомтоор нэвтэрч буй бэлэн валютын эргэлтийн 85%-ийг юань, 7%-ийг ам.доллар эзэлж байгаа бол Буянт Ухаа боомтоор дамжих бэлэн валютын эргэлтийн 55%-ийг ам.доллар, 25%-ийг юань тус тус эзэлж байна.
- Энэхүү түүвэр судалгааны үр дүн нь 2012 оны түүвэр судалгааны үр дүн болон арилжааны банкуудын касс дахь бэлэн мөнгө дансны үлдэгдэл, бэлэн валютын зузаатгалд үндэслэсэн тооцооллын үр дүнтэй нийцтэй байна.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Түүвэр судалгааны үр дүнг Төлбөрийн тэнцлийн бэлэн мөнгө, харилцах дансны мэдээллийн эх сурвалжаар ашиглах.
- Ингэхдээ судалгааны үр дүнг төлбөрийн тэнцэлд тусгасан, тусгаагүй үеийн хувилбаруудын харьцуулсан шинжилгээг гүйцэтгэж удирдлагад танилцуулсны үндсэнд ашиглаж эхлэх.
- Судалгаагаар цуглуулсан бусад нэмэлт мэдээллийг ашиглан бэлэн валютын урсгалын шинжилгээ хийх, аялал жуулчлалын үйлчилгээний дансны үзүүлэлтүүдийг баталгаажуулах.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Монгол - ОХУ-ын хилийн боомтууд

	Боомт	Төрөл	Байршил
1.	Алтанбулаг	Авто зам	Сэлэнгэ – Алтанбулаг
2.	Сүхбаатар	Төмөр зам	Сэлэнгэ – Сүхбаатар
3.	Эрэнцав	Авто зам/Төмөр зам	Дорнод – Чулуунхороот
4.	Ульханмайхан	Авто зам	Дорнод – Баян-Уул
5.	Цагааннуур	Авто зам	Баян-Өлгий - Цагааннуур
6.	Тэс	Авто зам	Увс – Тэс
7.	Боршоо	Авто зам	Увс – Давст
8.	Ханх	Авто зам	Хөвсгөл – Ханх
9.	Арцуурь	Авто зам	Завхан – Тэс
10.	Бага илэнх /Тэшиг/	Авто зам	Булган – Тэшиг

Хавсралт 2. Монгол - БНХАУ-ын хилийн боомтууд

	Боомт	Төрөл	Байршил
1.	Даян	Авто зам	Баян-Өлгий – Сагсай
2.	Байтаг	Авто зам	Ховд – Булган
3.	Бургастай	Авто зам	Говь-Алтай – Алтай
4.	Ханги	Авто зам	Дорноговь – Хатанбулаг
5.	Баянхошуу	Авто зам	Дорнод – Халх гол
6.	Хавирга	Авто зам	Дорнод – Чойбалсан
7.	Шивээхүрэн	Авто зам	Өмнөговь – Гурван тэс
8.	Гашуунсухайт	Авто зам	Өмнөговь - Ханбогд
9.	Сүмбэр	Авто зам	Дорнод – Халх гол
10.	Булган	Авто зам	Ховд – Булган
11.	Бичигт	Авто зам	Сүхбаатар – Эрдэнэцагаан
12.	Замын Үүд	Авто зам/Төмөр зам	Дорноговь – Замын Үүд